



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СӨНИН

№97
(97)

2021.07.23



Хүн төрөлхтний баяр цэнгэл ТОКИО-2020 Олимпын XXXII наадам өнөөдөр нээлтээ хийх гэж байна. Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний нэрийн өмнөөс тус наадамд спортын 7 төрлөөр 12 тамирчин эрх аван оролцож байна.

Тус наадамд Монгол Улс оролцож эхэлснээс хойш Зэвсэгт хүчний Алдар спорт хорооны тамирчид тасралтгүй оролцсон байдаг бөгөөд Олимпын наадмын мөнгө, хүрэл, шагналт байрыг нийт 13 тамирчин хүртсэн байна. Зэвсэгт хүчний төлөөлөл нийт тамирчин дайчиддаа амжилтын дээдийг хүсэн ерөөе.

“Итгэл бидний замыг гэрэлтүүлнэ”

Зуны 32 дахь “Токио-2020” олимпын XXXII наадам энэ өдрөөс эхлэн 8-р сарын 8 хүртэл явагдах бөгөөд түүнд дэлхийн 200 гаруй улс орноос, спортын 33 төрлөөр, 339 медалийн төлөө өрсөлдөх юм. Монгол Улсын 43 тамирчин “Токио-2020” олимпод спортын 10 төрөлд өрсөлдөнө. Цар тахалтай холбогдуулан жилийн хугацаанд хойшлон ийнхүү зохион байгуулагдаж буй дэлхийн энх тайвны бэлэг тэмдэг болсон олимпын наадам эхэлж байгаатай холбогдуулан зохион байгуулагч орны талаар олимптой холбоотой сонирхолтой мэдээллийг хүргэж байна.

“Итгэл бидний замыг гэрэлтүүлнэ” уриатай энэ удаагийн олимпод зохион байгуулж байгаа Япончууд хамгийн анх 1964 онд зуны Олимп зохион байгуулж байв. Энэ Олимп нь Монголын баг, тамирчдын оролцсон хамгийн анхны Олимп байсан юм.

Япончууд энэ удаагийн Олимпын наадамтай нийлээд нийт гурван удаа Зуны олимпыг

зохион байгуулах эрх авч байлаа. Тодруулбал, 1940, 1964 тэгээд одоо 2020 онд. Харин 1937 онд Япончууд Хятад руу дайран орсноор Олимпын наадам зохион байгуулах эрхийг нь хураан авч Финляндад зохиохоор өөрчилж байсан түүхтэй. Гэсэн хэдий ч Дэлхийн хоёрдугаар дайны улмаас 1940 болон 1944 онуудад Олимпын наадам зохиогдоогүй юм.

Ингээд 1952 онд Финляндад 1964 онд Японд зуны Олимпын наадам тус тус зохиогджээ. Финляндын Хелсинкид болсон зуны Олимпын наадам нь Олимпын бамбарыг нисэх онгоцоор зөөвөрлөсөн анхны тохиолдол болж байв. Дэлхийн хоёрдугаар дайн дууссанаас хойш ердөө 20 хүрэхгүй жилийн дотор Япончууд эдийн засгаа дахин сэргээж, 1964 он гэхэд нэг хүнд ноогдох Дотоодын нийт бүтээгдэхүүнээр дэлхийд дөрөвдүгээрт жагсаж байсан юм. Япончууд анх 1912 онд Олимпын наадамд оролцож, 1920 онд анхны медалиа, 1928 онд анхны алтан медалиа авч байснаас хойш

өнөөдрийг хүртэл нийт 439 медаль хүртсэнээс 156 нь алтан медаль юм. Түүнчлэн Япончууд жүдогийн төрөлд хамгийн олон алтан медаль хүртжээ.

Стокхольмд болсон 1912 оны Олимп Японы 2 тамирчин богино зайн гүйлт болон марафоны төрөлд оролцож байсан юм. Харин 2016 оны Риогийн Олимп Япончууд хамгийн

олон буюу 338 тамирчинтайгаар оролцож 41 медаль хүртсэнээс 12 нь алтан медаль байжээ. Тэгвэл энэ жил Япончууд нийт 552 тамирчинтайгаар Олимпын наадамд оролцох юм байна.

2024 оны Зуны Олимп Парист зохиогдох бөгөөд Парис хот 1924 онд анх зохиож байснаасаа хойш яг 100 жилийн дараа Олимпын наадмыг дахин зохион байгуулах юм.



ҮЙЛ ЯВДАЛ

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ХЗЦК-ЫН УДИРДЛАГА ХАМТ ОЛОН АХЛАХ АХЛАГЧ Э.ДАВААЖАМЦАД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ



Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн хөгжимчин, ахлах ахлагч Э.Даваажамц Ховдоос Дорнод аймаг хүртэл 2127 км замыг 46 хоногийн хугацаанд туулан Монгол цэргийн эр зориг, тэсвэр хатуужлыг ард түмэндээ илтгэн харуулсан билээ. Тэрээр зорьсон зорилгодоо хүрснээ илтгэхээр өчигдөр Зэвсэгт хүчний Хуурай замын Цэргийн командлалд очсон юм.

Түүнийг Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн штабын дарга, бригадын генерал Л.Онцгойбаяр, Төв аймгийн засаг дарга Д.Мөнхбаатар, болон командлалын бие бүрэлдэхүүн хүлээн авч уулзан, хүндэтгэл үзүүлжээ.

Орчин цагийн Зэвсэгт хүчин

үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг тохиолдуулан мөрдэс нэгт ахан дүүсийнхээ урам зоригийг бадрааж, ирээдүй хойч үедээ эх орноо хайрлах эр цэргийн бахархлыг үлгэрлэн харуулж Ховд-Улаанбаатар-Дорнод аймгийн чиглэлд гүйн “Хэт холын зайн гүйлтийн төрөл”-д Монгол Улсынхаа дээд амжилтыг шинэчлэн тогтоосонд Хуурай замын цэргийн командлалын удирдлага, хамт олны зүгээс талархал илэрхийлж ажилд нь амжилт хүсэж, дурсгалын зүйл гардуулж баяр хүргэсэн юм. Мөн энэ үеэр ахлах ахлагч Э.Даваажамц Төв аймгийн засаг дарга Д.Мөнхбаатар аймгийн “Хүндэт тэмдэг”-ийг гардуулан өгсөн юм.

Ахмад Ц.ГАНБАТ

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

| | | |
|-----------------------------|---------------------|-------------------|
| НИЙТ БҮРТГЭГДСЭН 152.539 | ЭДГЭРСЭН 144.245 | НАС БАРСАН 755 |
| +1309 | +2997 | +6 |

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

| | | |
|-------------------------|----------------------------|------------------|
| НИЙТ БАТЛАГДСАН 3932 | ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 262 | ЭДГЭРСЭН 3600 |
| +68 | +13 | +13 |

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

| |
|--------------------------------|
| Тохиолдол Нийт: 193,352,282 |
| Эдгэрсэн Нийт: 173,978,489 |
| Нас барсан Нийт: 4,150,578 |

ДЕЛЬТА ХУВИЛБАР АНХЛАРАХ ШИНЭ ШИНЖ ТЭМДЭГ

- Суулгах
- Хамар битүүрэх, нус гоожиж
- Булчин өвдөх
- Урт хугацаагаар толгой өвдөх
- Бөөлжих
- Хоолой өвдөх
- Бие тавиурх, идэрх

ДЭЭРХ ШИНЖ ТЭМДЭГ ИЛЭРВЭЛ ШИНЖИЛГЭЭ ӨГӨӨРӨЙ.

СПОРТ

ТОКИО-2020 олимпын наадамд оролцох “Алдар” спорт хорооны тамирчдыг цувралаар танилцуулж байна.

БХЯ-НЫ ХАРЬЯА “АЛДАР” СПОРТ ХОРООНЫ ЖУДО БӨХИЙН ТАМИРЧИН ОУХМ, ДЭСЛЭГЧ Г. АЛТАНБАГАНА



Д э с л э г ч Г.Алтанбагана нь 1995 оны 06 дугаар сарын 21-ний өдөр Улаанбаатар хотод төрсөн. Ам бүл 4. Аав, ээж, эгчийн хамт амьдардаг. 2002- 2012 онд Нийслэлийн 84 дүгээр дунд сургууль, 2013-2016 онд МУБИС-ийг Биеийн тамирын дасгалжуулагч мэргэжлээр бакалавр зэрэгтэй төгссөн.

Жудо бөхийн спортоор 2006 оноос хичээллэж эхэлсэн.

Г.Алтанбаганы Самбо, Жудо, Жюу-жицу бөхийн спортоор гаргасан амжилтууд:

2010 онд - Жудо бөхийн өсвөр үеийн Азийн аварга шалгаруулах тэмцээнээс хүрэл медаль

- Спортын дэд мастер цол

2011 онд - Спортын мастер цол -Жудо бөхийн Залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнээс мөнгөн медаль

2012 онд - Жудо бөхийн Монгол туургатны аварга шалгаруулах тэмцээнээс хүрэл медаль

“Темуйн сир”-залуучуудын аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль

-Жудо бөхийн ‘Taipei open’-олон улсын тэмцээнээс хүрэл медаль

- Жудо бөхийн өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль

-Самбо бөхийн өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль

-Жудо бөхийн Зүүн азийн аварга шалгаруулах тэмцээнээс хүрэл медаль

-Монгол улсын боловсролын их сургуулийн жудо бөхийн аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль

-Жудо бөхийн насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс мөнгөн медаль

-Самбо бөхийн залуучуудын азийн аварга шалгаруулах тэмцээнээс хүрэл медаль

- Кураш бөхийн насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль

тэмцээнээс алтан медаль

- Жудо бөхийн “Насанд хүрэгчдийн Багийн Улсын аварга” шалгаруулах тэмцээнээс мөнгөн медаль

-Самбо бөхийн насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс хүрэл медаль

-Жюу-Жицу бөхийн насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс мөнгөн медаль

- Жюу-Жицу бөхийн насанд хүрэгчдийн NO-Gi төрөлд улсын аварга шалгаруулах тэмцээнээс мөнгөн медаль

-Жудо бөхийн залуучуудын дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль

-Жудо бөхийн ‘Shon-ho cup’ оюутны аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль

2014 онд -Самбо бөхийн залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль

-Жудо бөхийн ‘Borjin cup’ залуучуудын аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль

-Жудо бөхийн ‘Asian open Taipei’ олон улсын залуучуудын аварга шалгаруулах тэмцээнээс хүрэл медаль

- Qindao Grand Prix олон улсын тэмцээнээс хүрэл медаль

- Жудо бөхийн ‘Hong kong international Judo Tournament’- олон улсын насанд хүрэгчдийн аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль

-Жудо бөхийн Зүүн азийн аварга шалгаруулах тэмцээнээс хүрэл медаль

- ОХУ-ын улсын Екатеринбург хотноо зохион байгуулагдсан жудо бөхийн Их Дуулга тэмцээнээс хүрэл медаль

- Насанд хүрэгчдийн 2018 оны жудо бөхийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль

- Хөх хотын Гран при тэмцээнээс мөнгөн медаль

- Индонез улсын Жакарта хотноо зохиогдсон тоглолтоос мөнгөн медаль тус тус хүртсэн.

2015 онд - Жудо бөхийн ‘Undes cup’ оюутны аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль

-Жудо бөхийн насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс мөнгөн медаль

- Олон улсын хэмжээний мастер цолоор шагнагдсан

2016 онд -Жудо бөхийн насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс мөнгөн медаль

-Жудо бөхийн оюутны улсын аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль

-Жудо бөхийн насанд хүрэгчдийн багийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс хүрэл медаль

- Жюу-Жицу бөхийн насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс алтан медаль

ҮЙЛ ЯВДАЛ

Д.Ганзориг: ШИНЭ ҮЕИЙН ТҮҮХИЙН НЭГ ХЭСГИЙГ МАНАЙ БАЙГУУЛЛАГА БАРИМТЖУУЛАН ХАДГАЛАХ БОЛСОНДОО БАЯРТАЙ БАЙНА



Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн хөгжимчин, ахлах ахлагч Э.Даваажамц Зэвсэгт хүчний хуурай замын цэргийн командлалд очсоны дараа Монгол Цэргийн музейд хүрэлцэн ирсэн юм. Ховдоос Дорнод аймаг хүртэл Монгол цэргийн эр зориг, тэсвэр хатуужлыг ард түмэндээ илтгэн харуулсан энэ үйл явдалтай холбогдуулан Монгол цэргийн музейн гүрээс түүний олон зуун километрийн турш хамт авч явсан Монгол Улсын Төрийн далбаа болон гүйхдээ өмсөж байсан цэргийн дүрэмт хувцас, эд хэрэгслийг нь түүхийн алтан сан хөмрөгтөө оруулах ёслолын арга хэмжээг зохион байгуулав.

Энэ үеэр Монгол цэргийн музейн захирал, хурандаа

Д.Ганзориг "Ахлах ахлагч Э.Даваажамц хэт хольн зайн гүйлтийг амжилттай туулж ирсэн нь цэрэг хүн ямар байх ёстойг харуулснаас гадна иргэн цэргийн харилцааг бэхжүүлэх, хүүхэд, залуучуудад эр оронч үзлийг төлөвшүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж чадсанаараа Зэвсэгт хүчний нэгэн түүх болон үлдэж байна. Музей бол аливаа түүхийн гэрч болон үлдсэн эд өлгийн зүйлийг хадгалан хамгаалж, сурталчлан таниулах үүрэг бүхий эрдэм шинжилгээний байгууллага юм. Энэ ч утгаараа энэхүү шинэ үеийн түүхийн нэг хэсгийг манай байгууллага баримтжуулан хадгалах болсондоо баяртай байна" гэж хэлээд түүний цаашдын амьдрал, ажил

үйлсэд нь өндөр амжилтыг хүсэн ерөөлөө. Харин ахлах ахлагч Э.Даваажамц "Зэвсэгт хүчнийхээ 100 жилийн ойгоор бэлэг барья гэж бодож энэ гүйлтийг эхлүүлж байсан. Улмаар энэ сарын 5-ны өдөр Улаанбаатар хотод ирж ЗХЖШ-д хүндэтгэл үзүүлэх үйл ажиллагаа дээр Монгол цэргийн музейн хамт олны зүгээс гүйхдээ өмсөж байсан дүрэмт хувцсыг үзвэр болгон хадгалах хүсэлтийг надад тавьсан. Тэр үед үгээр хэлж боломгүй сайхан санагдаж байсан. Харин өнөөдөр өөрийн хувцсаа энэхүү музейд гардуулан өгч байна. Дараа нь энд байршуулахад миний гүйж байсан үеийн сэтгэл, мэдрэмж тэр чигээрээ мэдрэгдэнэ гэдэгт итгэлтэй байна" гэв.

ЦАХИМ ШУУДАНД

АРДЫН ЖУРАМТ ЦЭРЭГ Ц.ХАСБААТАРЫН ХӨШӨӨНИЙ ЦОГЦОЛБОРЫГ СЭРГЭЭН ШИНЭЧЛЭВ



Баян-Өлгий аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

“Зэвсэгт хүчний 100 жил”-ийн ойг угтсан арга хэмжээний хүрээнд “Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр”, аймгийн Засаг даргын 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга хурандаа Ц.Нацагдорж, Монгол Улсын баатар Дамдины Намнангийн нэрэмжит, Цэргийн гавьяаны

хамтран ардын журамт цэрэг Ц.Хасбаатарын хөшөөний цогцолборыг сэргээн шинэчилж, өргөтгөл хийлээ. Түүхт Ц.Хасбаатарын хөшөөний нээлтийн арга хэмжээг 7 дугаар сарын 7-ны өдөр зохион байгууллаа. Уг арга хэмжээнд Баян-Өлгий аймгийн Засаг дарга Д.Бауыржан, Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга хурандаа Ц.Нацагдорж, Монгол Улсын баатар Дамдины Намнангийн нэрэмжит, Цэргийн гавьяаны

одонт, хилийн 0165 дугаар ангийн захирагч, хурандаа Р.Эрдэнэтгох, Бугат сумын Засаг дарга А.Жамбал болон бусад албаны төлөөлөл оролцлоо.

Аймгийн Засаг дарга Д.Бауыржан “Толбо нуурын тулалдаанд ялалт байгуулж, баруун нутгийг чөлөөлсөн Монгол, Орос дайчин эрсийн баатарлаг гавьяаг бидний хойч үе, хүүхэд, залуучууд мартаж учиргүй. Тэдэнд цаг ямагт өвөг дээдсийнхээ баатарлаг гавьяаг танин мэдүүлж, бахархах сэтгэл төрүүлэх нь бид бүгдийн үүрэг” хэмээн тэмдэглэж Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор баталсан “Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллахаа илэрхийллээ.

Мөн хөшөөг сэргээн засварлах барилгын ажлыг амжилттай хийж гүйцэтгэсэн Хилийн 0165 дугаар ангийн хамт олон болон бусад оролцсон байгууллагуудад баярласнаа илэрхийлж ажлын амжилт хүслээ.